



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/2023/6

Улаанбаатар хот

**Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг  
дээшлүүлэх жилийн хүрээнд “Бизнес эрхлэгчдийн  
зөвлөгөөн”, “Оёдолчдын ур чадварын уралдаан”-ыг  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жилийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв үүсгэн байгуулагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан “Оёдолчдын ур чадварын уралдаан”-ыг 2023 оны 10 дугаар сарын 26-нд, “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2.Арга хэмжээнд оролцох бичил, бизнес эрхлэгчдийн нэрсийг нэгдүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээг чанартай зохион байгуулж бичил, бизнес эрхлэгчдийн оролцоог ханган ажиллахыг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв (М.Өсөхдэлгэр)-д үүрэг болгосугай.

4.Арга хэмжээнд зарцуулагдах 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД